



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 118

Улаанбаатар хот

Г “Капитал маркет корпораци” ХХК-д 7
тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, 15.3.5 Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Капитал маркет корпораци” ХХК-д үнэт цаасны зах зээлд брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.

2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээн чанд биелүүлж, компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэл болон дүрмийн санд орсон өөрчлөлтийг улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж хуулбарыг 10 хоногийн дотор Хороонд ирүүлэхийг “Капитал маркет корпораци” ХХК /Д.Рэнцэн/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-д тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН